



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Мөст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2023/149/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Гэрэлт Хөхийн тэнцвэр Аудит ХХК-ны Ховд дахь салбар
Аудитор: Д.Хишгээ
Утас: 70432545
цахим хаяг: hishgee.da @ gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
Асуудлыг онцолсон хэсэг	3Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	3Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	7Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	7
4.2 Материаллаг байдал.....	8Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .	8Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	9Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10 Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар	11 Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.....	11Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12Error! Bookmark not defined.
5.1 Төлбөрийн акт.....	13
5.2 Албан шаардлага:	13 Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	Error! Bookmark not defined.15

Товчилсонүгийнжагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН МӨСТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Т.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

2023.02.16 № 02/43
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үрдүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Мөст сумын Хүүхдийн цэцэрлэг 2022 оны 12 дугаарсарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоонд дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮ5 ангиллаар олгосон, Хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, үүнийг хэрхэн төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 91 дугаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

Тус сургууль нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан бол тайлант оны эхний 3 сард тогтмол зардлын санхүүжилтийг орон нутгаас, сүүлийн саруудын санхүүжилтийг улсын төсвөөс авсан онцлогтой байна.

Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.96 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Засгийн Газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон. Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаалаар сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэгдэл урамшуулал олгоогүй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн А/192 дугаар тушаалын хавсралтын дагуу илүү цагийн хөлсийг олгохдоо дундаж цалин хөлс тооцох журмыг баримтлаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг 2022 онд хамран сургах тойргийн 197 хүүхэдтэй, үүнээс үндсэн бүлэгт 102 хүүхэд хувилбарт сургалтанд 74 хүүхэд хамрагдсан бөгөөд нийт 176 хүүхэд хамрагдаж хамран сургалт 89.3 хувьтай байна.

7 бүлэг 35 заалт бүхий ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргаар баталгаажуулж үр дүнг тооцож, 95 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалтнь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэжүздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,961,275.00	12,496,679.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	95,760.84
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	95,760.84
3122	Гадаад валют	-	95,760.84
31221	Төрийн сангийн харилцах	-	95,760.84
33	АВЛАГА	2,085,514.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,085,514.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	16,875,761.00	12,400,919.00
354	Хангамжийн материал	16,875,761.00	12,400,919.00
35420	Аж ахуйн материал	2,052,120.00	390,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,866,300.00	2,680,300.00
35460	Хүнсний материал	6,641,141.00	2,893,219.00
35470	Бусад хангамжийн материал	4,316,200.00	6,437,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,002,677,414.00	965,994,535.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,002,677,414.00	965,994,535.36
391	Газар		
392	Биет хөрөнгө	997,006,370.00	960,369,163.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,079,389,618.00	1,099,339,618.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(163,116,392.00)	(198,126,765.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	205,040,250.00	205,040,250.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(148,046,081.00)	(167,049,442.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,860,053.00	58,991,303.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,734,978.00)	(40,439,700.68)
39217	Ном	2,613,900.00	2,613,900.00
393	Биет бус хөрөнгө	5,671,044.00	5,625,372.36
39301	Програм хангамж	1,006,716.00	1,006,716.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(595,672.00)	(641,343.64)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,260,000.00	5,260,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,021,638,689.00	978,491,215.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	4,028,897.76
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,028,897.76
413	Өглөг	-	4,028,897.76
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,182,097.76
4136	Бусад өглөг	-	2,846,800.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,561,800.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	285,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,021,506,639.00	974,325,267.44
51	Засгийн газрын хувь оролцоо	1,021,506,639.00	974,325,267.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	50,306,835.00	50,306,835.00
51101	Өмч: - төрийн	50,306,835.00	50,306,835.00
512	Хуримтлагдсан үр дүн	492,068,218.00	444,886,846.44
51210	Өмнөх үеийн үр дүн	492,068,218.00	492,068,218.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	(47,181,371.56)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	479,131,586.00	479,131,586.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,021,506,639.00	978,354,165.20

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	314,505,215.00	322,616,350.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	280,865,200.00	1,122,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,122,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,122,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	1,122,200.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	280,865,200.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	280,865,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,640,015.00	321,494,150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	14,208,345.00	261,777,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	261,777,800.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	14,208,345.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,174,170.00	2,131,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,174,170.00	2,131,250.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,257,500.00	37,635,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,257,500.00	37,635,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	2,000,000.00	-
1330	Төсвийн захирагчдаас	-	19,950,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	19,950,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	347,834,943.21	369,797,721.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	347,834,943.21	369,797,721.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	307,992,628.38	369,797,721.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,968,811.03	218,704,321.00
210101	Үндсэн цалин	194,533,183.00	196,515,720.00
210102	Нэмэгдэл	524,272.03	-
210104	Урамшуулал	3,911,356.00	22,188,601.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,645,726.52	28,070,940.16
210201	Тэтгэврийн даатгал	17,539,944.96	19,305,967.32
210202	Тэтгэмжийн даатгал	2,026,445.39	2,191,243.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,621,156.30	1,752,994.58
210204	Ажилгүйдлийн даатгал	405,289.09	438,248.63
210205	Эрүүл мэндийн даатгал	4,052,890.78	4,382,486.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,307,396.20	17,078,409.60
210301	Гэрэл, цахилгаан	2,307,396.20	2,882,409.60
210302	Түлш, халаалт	6,850,000.00	14,196,000.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	6,531,474.79	12,943,310.40
210401	Бичиг хэрэг	68,900.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,428,600.00	4,802,190.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,200.00	-
210404	Ном, хэвлэл	25,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	274,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,720,174.79	5,595,650.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	2,545,470.00
2105	Нормативт зардал	8,936,000.00	33,127,922.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	8,936,000.00	33,127,922.00
2107	Томилолт, зочны зардал	71,900.00	-
210702	Дотоод албан томилолт	71,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	359,900.00	125,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,900.00	-

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	125,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,171,419.84	59,747,818.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	309,150.00	605,689.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	496,300.00	378,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,365,969.84	58,764,128.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,842,314.83	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,842,314.83	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,842,314.83	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(33,329,728.21)	(47,181,371.56)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(33,329,728.21)	(47,181,371.56)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,306,835.00	479,131,586.00	492,068,218.00	1,021,506,639.00
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	50,306,835.00	479,131,586.00	492,068,218.00	1,021,506,639.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,306,835.00	479,131,586.00	492,068,218.00	1,021,506,639.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(47,181,371.56)	(47,181,371.56)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,306,835.00	479,131,586.00	444,886,846.44	974,325,267.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	314,505,215.00	299,412,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	280,865,200.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	280,865,200.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	280,865,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,640,015.00	299,412,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	14,208,345.00	261,777,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	261,777,800.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	14,208,345.00	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,174,170.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,174,170.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,257,500.00	37,635,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,257,500.00	37,635,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	2,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	314,505,215.00	299,317,139.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314,505,215.00	299,317,139.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	274,662,900.17	299,316,549.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,444,539.00	216,703,739.16
210101	Үндсэн цалин	111,997,839.00	173,911,939.16

210102	Нэмэгдэл	72,927,600.00	37,843,000.00
210104	Урамшуулал	13,519,100.00	4,948,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,813,949.97	26,003,910.24
210201	Тэтгэврийн даатгал	19,156,149.97	17,910,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,164,400.00	1,987,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,731,800.00	1,655,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	432,800.00	404,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,328,800.00	4,046,610.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,696,396.20	17,017,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,048,396.20	3,117,500.00
210302	Түлш, халаалт	10,248,000.00	13,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,441,615.00	-
210401	Бичиг хэрэг	69,400.00	-
210402	Тээвэр, шатахуун	766,500.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,100.00	-
210404	Ном, хэвлэл	39,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	423,770.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,113,245.00	-
2105	Нормативт зардал	11,422,700.00	30,222,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41,900.00	-
210502	Хоол, хүнс	10,984,600.00	30,222,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	140,000.00	140,000.00
210604	Урсгал засвар	140,000.00	140,000.00
2107	Томилолт, зочны зардал	71,900.00	-
210702	Дотоод албан томилолт	71,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	467,600.00	444,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	444,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,164,200.00	8,784,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,634,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,164,200.00	3,150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,842,314.83	589.76
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,842,314.83	589.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,842,314.83	589.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	95,760.84
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	95,760.84
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	95,760.84

2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	299412900.00	299316549.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	299412900.00	299316549.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	299412900.00	299316549.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216799500.00	216703739.16
210101	Үндсэн цалин	174007700.00	173911939.16
210102	Нэмэгдэл	37843000.00	37843000.00
210104	Урамшуулал	4948800.00	4948800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26004500.00	26003910.24
210201	Тэтгэврийн даатгал	17910400.00	17910400.00

210202	Тэтгэмжийн даатгал	1987100.00	1987100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1655100.00	1655100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	404700.00	404700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4047200.00	4046610.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17017500.00	17017500.00
210301	Гэрэл, цахилгаан	3117500.00	3117500.00
210302	Түлш, халаалт	13500000.00	13500000.00
210303	Цэвэр, бохир ус	400000.00	400000.00
2105	Нормативт зардал	30,222,500.00	30,222,500.00
210502	Хоол, хүнс	30,222,500.00	30,222,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	140,000.00	140,000.00
210604	Урсгал засвар	140,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	444,000.00	444,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	444,000.00	444,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,784,900.00	8,784,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,634,900.00	5,634,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,150,000.00	3,150,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	299,412,900.00	299,412,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	261,777,800.00	261,777,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	261,777,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	261,777,800.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,635,100.00	37,635,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	37,635,100.00	37,635,100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		95,760.84

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэхүндсэн зорилготойгоор Мөст сумын сургуулийн өмнөх боловсрол олгох 112 хүүхэд, хувилбарт 23 хүүхдийг хамруулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын ажилтан томилсон, дотоод хяналтын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналт хэрэгжүүлж ажилладаг байна. Иймд дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Тайлант онд БШУЯ-ны дотоод аудитын алба болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2016 онд баталсан бөгөөд шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгасан байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөст сумын хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,1 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар буурсан байна. Өмнөх оноос мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данстын үлдэгдэлд өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	0.1	0.1
Авлага	2.1	-	(2.1)
Бараа материал	16.9	12.4	(4.5)
Үндсэн хөрөнгө	1,002.7	966.0	(36.7)
Нийт хөрөнгө	1,021.6	978.5	(43.1)
Өр төлбөр	-	4.0	4.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,021.6	974.5	(47.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,021.6	978.5	(43.1)

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- ✓ Өр төлбөр тайлант онд ндш, татвар бараа материалын 4,0 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 261.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 37.6 сая төгрөг, зарлагыг 299.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Боловсролын салбар нь үр дүн гүйцэтгэлд суурилсан төсвөөр төсвөө боловсруулснаар цалингийн зардлыг 58.4 сая төгрөгөөр, бусад урсгал зардлыг 4.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Тайлант оны батлагдсан төсвийг 62,5 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 261.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 37.6 сая төгрөг нийт 299.4 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, орон нутгийн төсөвт 0.005 сая төгрөгийг төвлөрүүлэн, 0.096 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 298.5 сая төгрөг буюу 100 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 0.096 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80111	Барилгын тогтмол зардал	17.2	17.2	-	100%
80112	Нийтлэг үйлчилгээ	20.5	20.5	0.0	100%
81605	Эрүүл мэндийг дэмжих	0.6	0.6	-	100%
81807	Хүүхдийн хоол	30.2	30.2	-	100%
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	1.3	1.3	-	100%
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	0.6	0.6	-	100%
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр	198.8	198.8	-	100%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	30.3	29.3	1.0	97%
	дүн	299.4	298.5	0.96	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Мөст сумын Хүүхдийн цэцэрлэг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Ховд дахь салбарын аудитор Д.Хишгээ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар хэрэгжүүлсэн.

Ховд аймгийн Мөст сумын Хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/05 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 357,4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7,1 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн тайлангийн нийт 322,6 сая төгрөгөөр 2 хувиар буюу 6,4 сая төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар тооцон 5,1 сая төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоосон болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аудитаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 6 горим сорил хэрэгжүүлсний үр дүнд илэрсэн зөрчлийн дэлгэрэнгүйг тайлангийн 5-д дэлгэрэнгүй оруулсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж, 60 тушаал шийдвэр мэдээлэхээс бүрэн мэдээлсэн, хуулийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Мэдээлэл технологи, Хичээл практикийн зардлаас шатахууны үнэ гаргасан Хангамжийн материалын зардлын төсвийг энэ онд бүгдийг бараа үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай 2021-10-29-ны 190 тоот тушаалтай нийцээгүй байна.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авч түлээ нүүрсний худалдан авалт зарцуулалтанд тавих хяналт, ил тод байдлыг ханган ажиллах зөвлөмж авч хэрэгжүүлэн ажилласан байна. Аудитын шийдвэрийн нийт биелэлт 100 хувьтай байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, оны эцэст салбарын зохион байгуулдаг худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 24683,6 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 21,4 сая төгрөгний Шилэн дансны тухай хуульд заасан 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг мэдээлэхээс 21,4 сая төгрөгийн 3 зарлагын гүйлгээ мэдээлээгүй, дахин мэдээлүүлж зөрчлийг арилгалаа.

3,2 сая төгрөгний зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 заалт бүхий 2 зөвлөмж хүргүүлээ.

Үүнд:

5.3 Зөвлөмж

5.3.1 Цалин хөлс ,нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:“2022 онд тус цэцэрлэг 218703.6 мянган төгрөгний цалингийн сантай бөгөөд НДХ-т 217244.5 мянган төгрөгний цалингийн санг тайлагнасан бөгөөд үүнээс 1478.1 мянган төгрөгний цалинг нийгмийн даатгалд тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансныөглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах заалт зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж :Сар бүрийнхээ бодсон цалинг Нийгмийн даатгалын хэлтэст явуулсан тайлантай тулган зөрүү дүнгээр нийгмийн даатгалын нөхөн тайлан гаргах

5.3.2 Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Мэдээлэл технологи, Хичээл практикийн зардлаас 1769,5 мянган төгрөгний шатахууны үнэ гаргасан нь Хангамжийн материалын зардлын төсвийг энэ онд бүгдийг бараа үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай 2021-10-29-ны 190 тоот тушаалтай нийцээгүй байна

Өгсөн зөвлөмж :

Батлагдсан төсөвт зардлаа зардлын зүйл ангиар үнэн зөв бүртгэж тайлагнах

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

¹Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Зөвлөмж		Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2022 онд тус цэцэрлэг 218703.6 мянган төгрөгний цалингийн сантай бөгөөд НДХ-т 217244.5 мянган төгрөгний цалингийн санг тайлагнасан бөгөөд үүнээс 1478.1 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалд тайлагнаагүй байна.	1.0	1,478.1	1.0	1,478.1		
Мэдээлэл технологи, Хичээл практикийн зардалаас шатахууны үнэ гаргасан	8.0	1,769.5	8.0	1,769.5		
Цалингийн зардлаас дээш зарлагын гүйлгээ мэдээлээгүй	3.0	21,436.0			3.0	21,436.0
Зөрчлийн дүн	12.0	24,683.6	9.0	3,247.6	3.0	21,436.0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *Х.БОЛДБААТАР*

АУДИТЫН МЕНЕЖЕР: *А.ЦЭЦЭГСҮРЭН*

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: *Д.ХИШГЭЭ*